

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/19/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙНТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272585, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.21 № 01/35
Тайлан -ЭБЛ № -Т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЖАВХЛАНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц ХИШИГЖАРГАЛ

19020195

D 2022/2022 оң/ALBAN BICHIG

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,820,767.00	26,879,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,820,767.00	26,879,150.00
354	Хангамжийн материал	39,820,767.00	26,879,150.00
35410	Бичиг хэргийн материал	1,852,000.00	466,700.00
35420	Аж ахуйн материал	23,211,766.00	18,250,149.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,129,660.00	156,870.00
35440	Түлц шатах тослох материал	4,189,857.00	886,947.00
35470	Бусад хангамжийн материал	8,437,484.00	7,118,484.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	760,790,363.86	835,094,659.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	760,790,363.86	835,094,659.80
392	Биет хөрөнгө	670,690,363.86	744,994,659.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	557,439,249.61	557,439,249.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,517,952.08	-40,647,440.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,725,600.00	198,888,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124,550,599.86	-123,246,333.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	259,795,777.79	290,846,532.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,296,142.22	-203,952,389.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,388,320.98	164,373,550.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,813,431.40	-102,935,943.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,924,674.24	6,924,674.24
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,475,793.20	-3,041,701.50
39217	Ном	70,660.00	346,460.00
393	Биет бус хөрөнгө	90,100,000.00	90,100,000.00
39301	Програм хангамж	2,050,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	88,600,000.00	88,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II	800,611,130.86	861,973,809.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	800,611,130.86	861,973,809.80
51	Засгийн газрын хувь оролцоо	800,611,130.86	861,973,809.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	485,339,397.00	485,339,397.00
51101	Өмч: - төрийн	485,339,397.00	485,339,397.00
512	Хуримтлагдсан үр дүн	-87,385,271.63	-26,022,592.69
51210	Өмнөх үеийн үр дүн	-128,861,056.40	-87,385,271.63
51220	Тайлант үеийн үр дүн	41,475,784.77	61,362,678.94
51300	Хөрөнгийн дахин үнэлтээний зөрүү	402,657,005.49	402,657,005.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	800,611,130.86	861,973,809.80

Төв аймэг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,607,287,033.41	1,648,822,205.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,776,833.41	82,848,505.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,997,042.00	82,848,505.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	82,398,785.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	449,720.00
122	Тусламжийн орлого	3,779,891.41	00.00
122001	Хандив тусламж (дотоод)	3,779,891.41	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,558,520,100.00	1,565,973,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,543,040,100.00	1,565,973,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,543,040,100.00	1,565,973,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,480,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,480,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,565,821,248.64	1,587,459,526.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,565,821,248.64	1,587,459,526.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,532,024,831.64	1,583,308,613.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,398,458.01	1,148,982,253.47
210101	Үндсэн цалин	882,169,162.01	908,091,724.41
210102	Нэмэгдэл	174,054,704.00	150,088,588.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,410,000.00	34,682,997.44
210104	Урамшуулал	34,764,592.00	56,118,963.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,671,800.00	153,671,800.00
210201	Тэтгэрийн даатгал	106,438,300.00	107,798,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,308,400.00	11,468,400.00
210203	ҮОМЦУ-ний даатгал	9,046,700.00	9,078,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,251,700.00	2,369,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,616,700.00	22,936,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,564,759.60	69,859,709.40
210301	Гэрэл цахилгаан	7,158,685.00	6,541,025.00
210302	Түлц халаалт	59,373,994.60	59,896,444.40
210303	Цэвэр, бохир ус	2,032,080.00	1,966,240.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	1,556,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,029,750.00	87,532,872.00
210401	Бичиг хэрэг	32,375,800.00	40,150,060.00
210402	Тээвэр, шатахуун	16,618,238.00	21,079,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,906,362.00	14,499,072.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,449,350.00	11,203,830.00
2105	Нормативт зардал	800,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,687,150.00	79,967,787.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,816,500.00	12,826,300.00
210604	Урсгал засвар	35,870,650.00	67,141,487.00
2107	Томилголт, зочны зардал	3,209,000.00	3,544,000.00
210702	Дотоод албан томилолт	3,209,000.00	3,544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,068,629.00	8,442,703.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,329,704.00	4,357,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	2,878,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,200.00	145,303.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,700,000.00	00.00
210807	Газрын төлбөр	265,725.00	264,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,695,285.03	31,007,489.06
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	42,695,285.03	31,007,489.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,796,417.00	4,150,912.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,463,461.00	2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,953,461.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,342,956.00	2,150,912.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,342,956.00	2,150,912.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)-(1)-(2)	41,475,784.77	61,362,678.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)-(3)-(4)	41,475,784.77	61,362,678.94

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Тзүүлэлт	/ төгрөгөөр /				
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцоосний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,339,397.0	402,657,005.5	-128,861,056.4	00.0	709,135,346.1
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.0	00.0	00.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,339,397.0	402,657,005.5	-128,861,056.4	00.0	709,135,346.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.0	00.0	00.0	00.0	00.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	50,000,000.0	00.0	00.0	00.0	50,000,000.0
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.0	00.0	00.0	00.0	00.0
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	41,475,784.8	00.0	41,475,784.8
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	-87,385,271.6	00.0	800,611,130.9
D01	2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	-87,385,271.6	00.0	800,611,130.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.0	00.0	00.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	-87,385,271.6	00.0	800,611,130.9
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.0	00.0	00.0	00.0	00.0
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.0	00.0	00.0	00.0	00.0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.0	00.0	00.0	00.0	00.0
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.0	00.0	00.0	00.0	00.0
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	61,362,878.9	00.0	61,362,878.9
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	-26,022,592.7	00.0	861,973,809.8

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,558,520,100.00	1,565,973,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,558,520,100.00	1,565,973,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,543,040,100.00	1,565,973,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,543,040,100.00	1,565,973,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,480,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,480,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,522,110,100.00	1,543,060,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,522,110,100.00	1,543,060,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,488,313,683.00	1,638,809,787.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,123,866,407.00	1,148,982,253.47
210101	Үндсэн цалин	880,437,111.00	908,091,724.41
210102	Намгадгал	174,054,704.00	150,088,568.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,410,000.00	34,682,997.44
210104	Урамшуулал	34,784,592.00	56,118,963.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,671,800.00	153,871,800.00
210201	Тэтгэврийн даатгал	106,438,300.00	107,798,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,308,400.00	11,468,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,046,700.00	9,078,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,261,700.00	2,389,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,816,700.00	22,936,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,305,448.00	69,569,709.40
210301	Гэрэл, цахилгаан	7,158,685.00	6,541,025.00
210302	Тулш, халаалт	59,117,680.00	59,896,444.40
210303	Цэвэр, бохир ус	2,032,080.00	1,966,240.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	1,556,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,794,902.00	87,314,632.00
210401	Бичиг хэрэг	33,631,400.00	38,764,760.00
210402	Тээвэр, шатахуун	20,745,000.00	17,777,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,906,362.00	14,499,072.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,832,140.00	15,673,700.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,784,800.00	66,074,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,010,500.00	5,074,800.00
210604	Урсгал засвар	35,784,000.00	60,999,990.00
2107	Томилолт, зочны зардал	3,209,000.00	3,544,000.00
210702	Дотоод албан томилолт	3,209,000.00	3,544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,068,629.00	8,562,703.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,329,704.00	4,477,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	2,878,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,200.00	145,303.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,700,000.00	00.00
210807	Газрын төлбөр	265,725.00	264,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,796,417.00	4,180,912.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,463,481.00	2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,953,461.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олговсон санхүүжилт, шилжүүлэг	9,342,936.00	2,180,912.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,342,936.00	2,180,912.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,410,000.00	22,913,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (6)	36,410,000.00	22,913,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,410,000.00	22,913,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,410,000.00	22,913,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,410,000.00	22,913,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-36,410,000.00	-22,913,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)-(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/төгрөгөөр/				
		Өмнөх оны		Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хамналт +
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,543,040,100.0	1,533,697,144.0	1,565,973,700.0	1,563,822,787.9	2,150,912.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,543,040,100.0	1,533,697,144.0	1,565,973,700.0	1,563,822,787.9	2,150,912.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,517,347,100.0	1,509,243,883.0	1,563,973,700.0	1,561,822,787.9	2,150,912.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,099,000.0	1,123,686,407.0	1,150,576,500.0	1,148,982,263.5	1,593,246.5
210101	Үндсэн цалин	903,015,000.0	880,437,111.0	928,491,500.0	908,091,724.4	20,399,775.6
210102	Нэмэгдэл	168,009,800.0	174,054,704.0	168,009,800.0	150,088,568.5	17,921,231.6
210103	Унаа жюуны хөнгөлөлт	34,230,200.0	34,410,000.0	34,230,200.0	34,882,997.4	-452,797.4
210104	Урамшуулал	19,844,000.0	34,784,592.0	19,844,000.0	56,118,963.2	-36,274,963.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,871,800.0	161,871,800.0	163,871,800.0	163,871,800.0	0.0
210201	Тэтгэрийн даатгал	106,438,300.0	106,438,300.0	107,798,300.0	107,798,300.0	0.0
210202	Тэтгэрийн даатгал	11,308,400.0	11,308,400.0	11,468,400.0	11,468,400.0	0.0
210203	ҮОМШЭ-ний даатгал	9,046,700.0	9,046,700.0	9,078,700.0	9,078,700.0	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,261,700.0	2,261,700.0	2,389,700.0	2,389,700.0	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,616,700.0	22,616,700.0	22,936,700.0	22,936,700.0	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,607,000.0	71,308,446.0	70,007,000.0	69,989,709.4	47,290.6
210301	Гэрэл, цахилгаан	7,858,100.0	7,158,685.0	7,458,100.0	6,541,025.0	917,075.0
210302	Тууц халгалт	59,120,400.0	59,117,880.0	58,920,400.0	59,896,444.4	-2,976,044.4
210303	Цэвэр, бохир ус	2,628,500.0	2,032,080.0	2,628,500.0	1,966,240.0	662,260.0
210304	Байрны түрээс	3,000,000.0	3,000,000.0	3,000,000.0	1,556,000.0	1,444,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	81,232,800.0	79,794,902.0	87,346,900.0	87,314,632.0	32,388.0
210401	Бичиг хэрэг	33,632,200.0	33,631,400.0	37,820,000.0	38,784,780.0	-1,144,780.0
210402	Тээвэр, шатахун	20,745,700.0	20,745,000.0	16,777,000.0	17,777,000.0	-1,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	17,249,900.0	15,906,362.0	14,449,900.0	14,499,072.0	-49,172.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,000.0	680,000.0	600,000.0	600,000.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн алгагдах, ахуйн эд зүйлс	8,925,000.0	8,832,140.0	17,900,000.0	15,673,700.0	2,226,300.0
2105	Норматив зардал	800,000.0	800,000.0	800,000.0	800,000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн зүйл	800,000.0	800,000.0	800,000.0	800,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,999,000.0	62,724,500.0	89,000,000.0	88,987,790.0	12,210.0
210601	Багаж, төмж, хэрэгсэл	14,999,000.0	11,990,500.0	23,000,000.0	22,987,800.0	12,200.0
210602	Тавигта	15,000,000.0	14,950,000.0	5,000,000.0	5,000,000.0	0.0
210604	Урсгал засвар	36,000,000.0	35,784,000.0	61,000,000.0	60,999,990.0	10.0
2107	Томилголт, зочны зардал	3,518,700.0	3,209,000.0	3,868,700.0	3,544,000.0	324,700.0
210702	Дотоод албан томилголт	3,518,700.0	3,209,000.0	3,868,700.0	3,544,000.0	324,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,418,800.0	16,068,629.0	8,708,800.0	8,562,703.0	144,997.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,495,200.0	4,329,704.0	4,495,200.0	4,477,500.0	17,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0	720,000.0	720,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,878,200.0	2,800,000.0	2,878,200.0	2,878,000.0	200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,500.0	176,200.0	213,500.0	145,303.0	68,197.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.0	77,000.0	132,000.0	77,000.0	55,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,700,000.0	7,700,000.0	0.0	0.0	0.0
210807	Газрын төлбөр	279,900.0	266,725.0	284,900.0	264,900.0	9.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,693,000.0	24,463,461.0	2,000,000.0	2,000,000.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,693,000.0	24,463,461.0	2,000,000.0	2,000,000.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,193,000.0	19,953,461.0	0.0	0.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шалгалт урамшуулал	4,500,000.0	4,500,000.0	2,000,000.0	2,000,000.0	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,543,040,100.0	1,543,040,100.0	1,565,973,700.0	1,565,973,700.0	0.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,543,040,100.0	1,543,040,100.0	1,565,973,700.0	1,565,973,700.0	0.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,543,040,100.0	1,543,040,100.0	1,565,973,700.0	1,565,973,700.0	0.0
01	БАЙГУУЛЛАГЫН ТОО		01	01	01	01
610001	Төсвийн байгууллага		01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		61	61	63	63
620001	Удирдах ажилтан		05	05	05	05
620002	Гүйцэтгэх ажилтан		40	40	42	42
620003	Үйлчлэх ажилтан		06	06	06	06

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүн таслах үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, мэдээллийн технологийн дэвшлийг шүүхийн үйл ажиллагаанд эрчимтэй нэвтрүүлэх ажлын хүрээнд шүүхийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй, чирэгдэлгүй соёлтой хүргэх, үйлчилгээний байгууллагын стандартыг хэвшүүлэх чиг үүрэгтэй төрийн тусгай байгууллага юм.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газарт дотоод хяналт шалгалтыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Хяналт шалгалт үнэлгээ дотоод аудитын албанаас хийдэг байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллагад Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Хяналт шалгалт үнэлгээ дотоод аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй тул дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,607.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 24.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16.9 сая төгрөгөөр тогтоосон.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос зөрүү бага тул дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Шүүхийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,566.0 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 82.8 сая төгрөг нийт 1,648.8 сая төгрөг өмнөх оноос 41.5 сая төгрөгөөр буюу 2.58 хувиар өссөн байна.

Зардал :

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,587.4 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,543.1 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,563.8 сая төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140005001 тоот дансанд 2021 онд 1,548.0 сая төгрөгийн орлого, 1,548.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	39.8	26.9	12.1
Үндсэн хөрөнгө	760.8	835.1	-74.3
Нийт хөрөнгө	800.6	862.0	-61.4
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	800.6	862.0	-61.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	800.6	862.0	-61.4

Бараа материалын дансны үлдэгдэл 26.9 сая төгрөг болж 12.1 сая төгрөгөөр буурсан нь бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 835.1 сая төгрөг болж 74.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 22.9 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 82.4 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 862.0 сая төгрөг болж 61.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,930.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,930.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 437.0 сая төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,493.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь конторын барилгын их засварын зардлыг бууруулсантай холбоотой байна.

Монгол Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын төсвийн хуваарийг 2020 оны 12 дугаар сард 1,493.0 сая төгрөгөөр ирүүлж, 2021 оны 11 сард тодотгон 1,566.0 сая төгрөг болгон ирүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,566.0 сая төгрөгийн төсөв баталснаас 1,566.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,566.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,563.8 сая төгрөгийг зарцуулж, 2.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,563.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь 2.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нэмэлт санхүүжилтийн дансаар мөнгө зарцуулаагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар улсын төсвийн хөрөнгөөр 17.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс 62.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 13.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 7.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, номын фонд 0.3 сая

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төгрөг, 0.4 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар конторын дээврийн засварт 29.7 сая төгрөг, шүүх хуралдааны 4 танхимын засварт 24.5 сая төгрөг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар шүүхийн цахим архив үүсгэж, гэрэгэ киоск төхөөрөмжийг 3.5 сая төгрөгөөр худалдан авсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12, зарлагын 13 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 9 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, арвилан хэмнэлт үр ашигтай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Шүүхийн тамгын газрын даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 161 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 72.2 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн гүйлгээг шалгахад 2 буюу 0.3 сая төгрөгийн гүйлгээг шууд зардалд бичсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 388 дугаар тушаал “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Сангийн сайдын 388 дугаар тушаал “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар мөрдөж ажиллах.

1.3 Илрүүлэлт

Худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 71.9 сая төгрөгийн 17 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая

төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Шүүхийн тамгын газар	2	72.2							2	72.2

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70272287
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn